



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг
ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨВА-2024/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2024 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323108 Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn

Аудитор: Б.Баяртогтох

Утас: 70323833 Цахим хаяг: bayartogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн
тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий
зүйл
 - 4.2 Материаллаг
байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн
хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын
асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн
хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах
асуудал
5. Аудитын
илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндангийн гудамж
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг 52173
Утас/Факс: (976) 7032 3253
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.12 № 117

танай _____-ны № _____-и

АРВАЙХЭЭР ХОТЫН НИЙТИЙН
ТЭЭВЭР, ГЭРЭЛТҮҮЛЭГ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тус газар нь 2023 онд туслах үйл ажиллагааны орлогоор 24,635.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, Арвайхээр сумын ЗДТГ-аас зарласан "Нийтийн тээврийн ашиглалтыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх" тендерт шалгаран 69,300.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 383,619.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Тендерийн санхүүжилтээр 18,550.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, орлогод тусгасан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд 67,623.4 мянган төгрөгийн шатахуун, 57,296.7 мянган төгрөгийн бараа материалыг тус тус худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн.

Бусад мэдээллийн талаар онцлог анхаарал татсан зүйлгүй байна.

015030654

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл ₮	Эцсийн үлдэгдэл ₮
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22385569.68	29588054.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	159259.68	1599504.78
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	50.00	50.00
31110	Төгрөг	50.00	50.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	159209.68	1599454.78
3121	Төгрөг	159209.68	1599454.78
31213	Арилжааны банк дахь харилцах	159209.68	1599454.78
33	АВЛАГА	735700.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	735700.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21490610.00	27988550.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1551060.00	5950800.00
354	Хангамжийн материал	19939550.00	22037750.00
35410	Бичиг хэргийн материал	197050.00	195250.00
35420	Аж ахуйн материал	14860500.00	14860500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4882000.00	6982000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1053775269.74	705858691.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1053775269.74	705858691.14
392	Биет хөрөнгө	1053775269.74	705858691.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	523415172.00	523415172.00
39204	Хуримлагдсан элэгдэл	-262032071.86	-318019732.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27760000.00	28889900.00
39206	Хуримлагдсан элэгдэл	-27220416.77	-27628750.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1986954.00	1986954.00
39208	Хуримлагдсан элэгдэл	-1931954.00	-1986954.00
39209	Зам, гүүрийн байгууламж	69361330.00	86782230.00
39210	Хуримлагдсан элэгдэл	-37461330.00	-53274464.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	1855926580.28	1855926580.28
39215	Хуримлагдсан элэгдэл	-1096028993.91	-1390232243.98
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1076160839.42	735446745.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13772292.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13772292.00	0.00
413	Өглөг	13772292.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	360542.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13411750.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1062388547.42	735446745.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1062388547.42	735446745.92
512	Хуримлагдсан үр дүн	1062388547.42	735446745.92
51210	Өмнөх үеийн үр дүн	1467599867.41	1062388547.42
51220	Тайлант үеийн үр дүн	-405211319.99	-326941801.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1076160839.42	735446745.92

**Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	419180344.00	477555781.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419180344.00	477555781.71
120	Нийтлэг татварын бус орлого	419180344.00	477555781.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	419180344.00	477555781.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	286811200.00	383619800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129369144.00	93935981.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3000000.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	824391663.99	804497583.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	824391663.99	804497583.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	823611663.99	804497583.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113786301.00	144158604.00
210101	Үндсэн цалин	113786301.00	144158604.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14154561.00	17789921.44
210201	Тэтгэврийн даатгал	14154561.00	17789921.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88334154.00	94007840.00
210301	Гэрэл, цахилгаан	88334154.00	91607840.00
210304	Байрны түрээс	0.00	2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61197770.00	88405750.00
210401	Бичиг хэрэг	321400.00	4536600.00
210402	Тээвэр, шатахуун	46035560.00	62647600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	528000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14840810.00	20693550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91335786.00	2200000.00
210604	Урсгал засвар	91335786.00	2200000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11962164.00	4518829.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10740914.00	570000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784000.00	1200000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	2513500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132000.00	132000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	305250.00	103329.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	442840927.99	453416638.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21544080.00	86949260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	421296847.99	366467378.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-405211319.99	-326941801.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-405211319.99	-326941801.50

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	416180344.00	477555781.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	416180344.00	477555781.71
120	Нийтлэг татварын бус орлого	416180344.00	477555781.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	416180344.00	477555781.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	286811200.00	383619800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129369144.00	93935981.71
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	406395588.00	457564736.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406395588.00	457564736.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405615688.00	457564736.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114161459.00	143783446.00
210101	Үндсэн цалин	114161459.00	143783446.00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14154561.00	17789921.44
210201	Тэтгэврийн даатгал	14154561.00	17789921.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96757798.00	94007840.00
210301	Гэрэл, цахилгаан	96757798.00	91607840.00
210304	Байрны түрээс	0.00	2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40626370.00	76977850.00
210401	Бичиг хэрэг	271900.00	4519800.00
210402	Тээвэр, шатахуун	39740310.00	67623450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	528000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	614160.00	4306600.00
2105	Нормативт зардал	715000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	715000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73913850.00	114180850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	683000.00	4409000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	1096000.00
210604	Урсгал засвар	73230850.00	108675850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11962164.00	4518829.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10740914.00	570000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784000.00	1200000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	2513500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132000.00	132000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	305250.00	103329.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53324386.00	6306000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53324386.00	6306000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	780000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	780000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9784756.00	19991045.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10436000.00	18550800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10436000.00	18550800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10436000.00	18550800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10436000.00	18550800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10436000.00	-18550800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-651244.00	1440245.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	810503.68	159259.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159259.68	1599504.78

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,467,599,867.41	0.00	1,467,599,867.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,467,599,867.41	0.00	1,467,599,867.41
C07	Тайлант үеийн үр дүн	-405,211,319.99	0.00	-405,211,319.99
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,062,388,547.42	0.00	1,062,388,547.42
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,062,388,547.42	0.00	1,062,388,547.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,062,388,547.42	0.00	1,062,388,547.42
D08	Тайлант үеийн үр дүн	-326,941,801.50	0.00	-326,941,801.50
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,446,745.92	0.00	735,446,745.92

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290079430.00	406395588.00	451767845.00	457564736.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290079430.00	406395588.00	451767845.00	457564736.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290079430.00	405615588.00	451767845.00	457564736.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125386700.00	114161459.00	196804200.00	143783446.00
210101	Үндсэн цалин	110602700.00	114161459.00	169804200.00	143783446.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14784000.00	0.00	27000000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18181070.00	14154561.00	24600525.00	17789921.00
210201	Тэтгэврийн даатгал	18181070.00	14154561.00	24600525.00	17789921.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76100000.00	96757798.00	108500000.00	94007840.00
210301	Гэрэл, цахилгаан	76100000.00	96757798.00	108500000.00	91607840.00
210304	Байрны түрээс				2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37577500.00	40626370.00	65051500.00	76977850.00
210401	Бичиг хэрэг	730000.00	271900.00	2484000.00	4519800.00
210402	Тээвэр, шагахуун	35780500.00	39740310.00	60580000.00	67623450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540000.00	0.00	540000.00	528000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	527000.00	614160.00	1447500.00	4306800.00
2105	Нормативт зардал	0.00	715000.00	4320000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		715000.00	4320000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29954160.00	73913850.00	48369520.00	114180850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		683000.00		4409000.00
210602	Тавилга	1180000.00	0.00	1600000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1281300.00	0.00	6269520.00	1086000.00
210604	Урсгал засвар	27492860.00	73230850.00	40500000.00	108675850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2880000.00	11962164.00	4122100.00	4518829.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр ху	2880000.00	10740914.00	2400000.00	570000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		784000.00		120000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			1722100.00	2513500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		132000.00		132000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		305250.00		103329.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	53324386.00	0.00	6306000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		53324386.00		6306000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	780000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	780000.00	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		780000.00		0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394049200.00	416180344.00	451767845.00	477555781.71
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	394049200.00	286811200.00	416188400.00	383619800.00
122005	Орон нутгийн төсвөөс	394049200.00	286811200.00	416188400.00	383619800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	129369144.00	35599445.00	93935981.71
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		129369144.00	35599445.00	93935981.71
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			159209.68	159209.68
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				1599454.78

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ нь Хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэн, нийтийн эзэмшлийн зам талбайн тэмдэг тэмдэглэгээ, явган зам, хайс хашлага, гэрэлтүүлэг болон, урсгал засваруудыг тогтмол зохион байгуулах, нийтийн тээврийн үйл ажиллагааг тогтоосон цаг, хуваарийн дагуу ард иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Үүнд:

1. Хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэн, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээ, хайс, хашлаганы урсгал засваруудыг тогтмол зохион байгуулахтай холбоотой арга хэмжээ зорилтын хүрээнд:
 - Арвайхээр сумын хэмжээнд 10 м өндөртэй 200 вт-ын гэрэлтүүлгийн толгойтой 120 ширхэг цамхагт гэрлээс 1-р багт 9 ширхэг, 9-р багт 7 ширхэг, 12-р багт 11 ширхэг, 7-р багт 8 ширхэг, 3-р багт байгаа цамхагт гэрэлтүүлгийн толгойг бүрэн асааж завсарласан. Гэрэлтүүлгийн урсгал засвар бүрэн хийгдэж нийт гэрэлтүүлгийн 85% нь асааж байна.
 - Арвайхээр сумын 1, 9 дүгээр багт байх автобусны зогсоолын тэмдэг 6 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг шинээр байршуулав мөн авто машин мөргөж унагасан, гэмтээсэн 11 ширхэг тэмдэглэгээг засварлаж байршуулав.

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Нийтийн тээврийн үйл ажиллагааг тогтоосон цагийн хуваарийн дагуу ард иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллах зорилтын хүрээнд :
 - Арвайхээр сумын хэмжээнд нийт 22 ширхэг автобусны буудал байдгаас захын хороолол болох 10,11,1,9-р багийн 18 ширхэг автобусны буудлыг эвдэж гэмтээсэн ба 9 дугаар сард нийт 10 автобусны буудлыг 10 ширхэг зориулалтын хатаасан шилээр шиллэж, 12-р багын шинээр хийсэн авто замд 2 ширхэг автобусны буудал байршуулж, захын зүүн баруун талын хаалганд байсан автобусны буудлуудыг шинээр сольж байршуулсан. Мөн сандал болон автобусны буудлыг будаж засварласан.
 - 2023 оны 06 сарын 01-ээс нийтийн тээврийн үйлчилгээг 2 чиглэлд явдаг байсныг 5 чиглэлд явдаг болгож шинэ маршрутаар явуулдаг болсон.
 - Нийтийн тээврийн үйлчилгээг Арвайхээр сумын алслагдсан багын 5 чиглэлд явуулснаар 2022 оны нийтийн тээврийн орлогоос 2023 онд нийтийн тээврийн орлого 20-25%-тай өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Авто тээврийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Тайлант хугацаанд Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд боловсруулан мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 340,7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	159.2	1,599.5	1,440.3
Авлага			
Бараа материал	21,490.6	27,988.5	6,497.9
Үндсэн хөрөнгө	1,053,775.3	705,858.7	-347,916.6
Нийт хөрөнгө	1,076,160.8	735,446.7	-340,714.1
Өр төлбөр	13,772.3		-13,772.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,062,388.5	735,446.7	-326,941.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		735,446.7	-340,714.1

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын тайлант онд батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөөг 451.7 сая төгрөгөөр Удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 20-ны 01 тоот тогтоолоор баталсан. Үүнд: гэрэлтүүлэг 278.4 сая, нийтийн тээвэрт 173.3 сая төгрөгийн төлөвлөгөө баталсан.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 383.6 сая төгрөгөөр санхүүжигдэж, туслах үйл ажиллагааны орлогоор 93.9 сая төгрөг оруулж, 475.9 сая төгрөг зарцуулжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр хотын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Баяртогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 7 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 80 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын дүн 804.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 32 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн. Энэ хуулийн хүрээнд зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	5,569.0	2	5,569.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	5,569.0	2	5,569.0	100

/мянган төгрөгөөр/

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өмнөх аудитаар бараа материалын тайлан, орлоготой холбоотой 2 албан шаардлага өгөгдөж бүрэн хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэхэд анхаарч ажиллах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажиллах,

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 20.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан бүртгэж, 124.9 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

- Тайлант онд 67,623.4 мянган төгрөгийн шатахуун, 57,296.7 мянган төгрөгийн бараа материалыг тус тус худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т "шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-т заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

5.3 Зөвлөмж

Тус байгууллага зөвлөмж өгөгдөөгүй байна. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 20.790.0 мянган төгрөгийг орлогын ангиллыг буруу, 42.1 мянган төгрөгийг илүү бүртгэсэн	1	20832.1			1	20832.1	1	20832.1				
Дүн	1	20832.1			1	20832.1	1	20832.1				

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 67,623.4 мянган төгрөгийн шатахуун, 57,296.7 мянган төгрөгийн бараа материалыг тус тус худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	124,920.1			1	124,920.1						
Дүн	1	124,920.1			1	124,920.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

